

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

ГАРЧИГ

1. БИДНИЙ ТУХАЙ, МАНАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
2. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР
3. ДАНС ХЭРХЭН НЭЭХ ВЭ?
4. БИД ЯМАР БОЛЗОЛ, НӨХЦӨЛ САНАЛ БОЛГОЖ АЖИЛЛАДАГ ВЭ?
 - 4.1. Түншийн эрх, үүрэг
 - 4.2. Прүүвэ Монгол дахь салбарын үүрэг
 - 4.3. Харилцан хүлээж буй үүрэг
 - 4.4. Хамтын ажиллагаа, харилцан хүлээж буй эрх, үүрэг
 - 4.5. Түншийн Бүтээгдэхүүн борлуулахад баримтлах журам
 - 4.6. Цахим хуудас, нийгмийн сүлжээнд хуудас нээх, эрхлэхэд баримтлах журам
5. БИД ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ЯМАР ЖУРАМ БАРИМТАЛДАГ ВЭ? БИД ЯМАР ҮЙЛДЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХОРИГЛОДОГ ВЭ?
 - 5.1. Үйл ажиллагааны журам
 - 5.2. Хориотой үйлдэл, үйл ажиллагаа
 - 5.3. Үйл ажиллагааны журам болон хоригийг зөрчсөн тохиолдолд үүсэх үр дагавар
6. БИД ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН БОЛОВСРУУЛЖ, ХАМГААЛДАГ ВЭ?
7. БИД ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫГ ХЭРХЭН ШИЙДДЭГ ВЭ?
8. НУУЦЫН ЗЭРЭГТ ХАМААРАХ МЭДЭЭЛЭЛ ГЭЖ ЯМАР МЭДЭЭЛЭЛ ВЭ, БИД МЭДЭЭЛЛИЙН НУУЦЫГ ХЭРХЭН ХАМГААЛДАГ ВЭ?
9. ГЭРЭЭНИЙ ДУУСАХ ХУГАЦАА, ХЭЗЭЭ ГЭРЭЭГ ЗОГСООЖ БОЛОХ ВЭ, ГЭРЭЭ БОЛОН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХЭЗЭЭ ЦУЦЛАХ ВЭ?
 - 9.1. Гэрээ дуусгавар болох нь
 - 9.2. Гэрээг түтгэлзүүлэх (түр зогсоох) тухай
 - 9.3. Гэрээг цуцлах тухай
 - 9.4. Гэрээг цуцласны дараа талуудын хүлээх үүрэг
 - 9.5. Гэрээг цуцласны дараах Түншийн бүртгэлийн дугаар, мэдээлэл
10. ТАНЫ МЭДЭЖ БАЙХ ЁСТОЙ БУСАД ЗҮЙЛС

1. Ерөнхий үйл ажиллагаа

Прүүвэ Монгол дахь салбар нь сонгодог олон үет маркетингийн аргаар үйл ажиллагаагаа явуулна.

Прүүвэ Монгол дахь салбар Түншүүддээ өндөр чанартай бүтээгдэхүүн, карьер бүтээх шинэлэг төлөвлөгөөг санал болгон дэмжиж ажиллана. Нэмэлт орлого олох бүрэн боломжийг Түншүүддээ олгохын зэрэгцээ тэднийг сэтгэл хангалуун байлгахыг зорин ажиллана.

Прүүвэ Монгол дахь салбар амьдралыг Түншүүдийнхээ хөгжил, дэвшилд хүрэх онцгой нэг боломж гэж үздэг бөгөөд үйл ажиллагаандаа баримталдаг аливаа журмыг тогтвортой, удаан хугацааны хамтын ажиллагааг баталгаажуулах үндэс гэж үздэг.

Прүүвэ нэрийн бүтээгдэхүүн нь хосгүй өвөрмөц бөгөөд хүн бүрийн хүсэл сонирхолд нийцүүлэн бүтээсэн билээ.

Прүүвэ компани нь зах зээлд брэнд бүтээгдэхүүн гаргахын тулд хүчин чармайлт гарган ажилладаг бөгөөд энэ нь Прүүвэ нэрийн бүтээгдэхүүнийг компанийн үйл ажиллагааны журмын дагуу худалдаалж хэрэглэгчдэд хүргэх Түншүүдийн тоо цаг үргэлж нэмэгдэх гол хүчин зүйл болдог.

Хамтын ажиллагааны гэрээ нь Прүүвэ Монгол дахь салбар болон Түншийн хооронд үүсэх хамтын ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлох зорилготой болно. Уг гэрээгээр Прүүвэ Монгол дахь салбар-тай байгуулсан хамтын ажиллагаанаас үүсэх эрх, үүрэг болон зохисгүй буюу хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх ёс зүйн хэм хэмжээг тогтооно.

Прүүвэ Монгол дахь салбар борлуулсан бүтээгдэхүүний дүнгээс хамааруулж зохих урамшуулалыг Түншид олгоно. Прүүвэ Монгол дахь салбарын Түнш бүр бие даасан Гэрээт гүйцэтгэгч бөгөөд түүний санхүүгийн амжилт нь түүний хувийн гүйцэтгэлээс хамаарна. Иймээс Карьер төлөвлөлтийн аль хэсэгт байхаас үл хамааран Түнш бүр сарын хугацаанд бүтээгдэхүүн борлуулж тэмдэглэл хөтлөх бүрэн боломжтой билээ.

Энэхүү гэрээний 5 дугаар зүйлд заасны дагуу Хамтын ажиллагааны болзол, нөхцөл Карьер төлөвлөлт нь Прүүвэ Монгол дахь салбар болон Түншийн хооронд байгуулсан Гэрээний салшгүй хэсэг болно. Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллах гэрээг байгуулснаар Түнш тус бүр Хамтын ажиллагааны гэрээ, Үйл ажиллагааны журам, Карьер төлөвлөлт зэргийг сайтар уншиж судлан, дагаж мөрдөх үүрэгтэй.

Прүүвэ Монгол дахь салбарынбүх Түнш үйл ажиллагаагаа шударгаар явуулж, нийгмийн хариуцлагын өндөр жишиг баримтална.

2. Нэр томъёоны тайлбар

Хамтын ажиллагааны гэрээ, Карьер төлөвлөлт болон бусад баримт бичигт орсон нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

1. **Түншид санал болгох үнэ, хөнгөлөлт** гэдгийг Прүүвэ Монгол дахь салбарынзүгээс Түншид санал болгож буй бүтээгдэхүүн борлуулах үнэ гэж ойлгоно. Уг үнийг Прүүвэ Монгол дахь салбарынwww.mn.prouve.com цахим хуудсаар нэвтрэх онлайн /цахим/ дэлгүүрт байршуулсан байх бөгөөд Түнш уг цахим хуудас руу өөрийн бүртгэлтэй хаягаар нэвтэрнэ.
2. **Хэрэглэгч** гэдгийг өөрийн хэрэгцээнд Түншээс бүтээгдэхүүн худалдан авч буй хүн буюу эцсийн хэрэглэгч гэж ойлгоно.
3. **Түншийн бүртгэлтэй данс** (Данс) гэдгийг Прүүвэ Монгол дахь салбарынцахим системд бүртгэгдсэн, компанийн баталгаажуулсан Түншийн цахим данс гэж ойлгох бөгөөд Түнш өөрийн хэрэглэгчийн нэр, нууц үгийг оруулан данс руугаа нэвтэрнэ.
4. **Прүүвэ нэрийн бүтээгдэхүүний тэмдэг (Брэнд бүтээгдэхүүн)** гэдгийг Прүүвэ компанийн болон Прүүвэ Монгол дахь салбарынБНПУ-ын Оюуны

Өмчийн Газар, Европын Холбооны Оюуны Өмчийн Газар (ЕХОУБ), Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага (ДООБ) болон уг бүтээгдэхүүнийг борлуулж буй улсын оюуны өмчийн газарт мэдэгдэж бүртгүүлсэн худалдааны тэмдэг, бүтээгдэхүүний загварт хамаарах бүхий л эрх (зохиогчийн эрх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өмч) гэж ойлгоно.

5. **Түншийн хувийн дугаар** гэж хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж хамтын ажиллагаа байгуулсан Түншид олгосон дахин давтагдашгүй дугаарыг гэж ойлгоно.
6. **Спонсорын дугаар** гэдгийг Түншийн гэрээнд бичигдсэн тухайн Түншийн ивээн тэтгэгч буюу Түншийг урьсан Түншийн дугаар гэж ойлгоно.
7. **Элсэлтийн багц** гэдгийг Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллах шинэ Түншид тусгайлан зориулж сонгон бэлтгэсэн бүтээгдэхүүн болон тест бүтээгдэхүүнийг гэж ойлгоно.
8. **Прүүвэ Монгол дахь салбарын Түнш** гэдгийг хамтын ажиллагааны Гэрээ байгуулан Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллаж буй этгээд гэж ойлгоно.
9. **Прүүвэ Монгол дахь салбарын гадаад улс дахь салбар** (Салбар) гэдгийг Прүүвэ Монгол дахь салбарын франчайзингийн гэрээний дагуу хамтран ажиллаж буй хууль ёсны аж ахуйн нэгж гэж ойлгоно.
10. **Карьер төлөвлөлт гэдэг** нь хамтын ажиллагааны гэрээний салшгүй хэсэг бөгөөд үүгээр Түншид Түншлэлийн шат бүрд хамаарах хамтын ажиллагааны болзол, нөхцөл, урамшууллыг зааж зохицуулна.
11. **Бүтээгдэхүүн** гэдгийг Прүүвэ брэндийн тэмдэг бүхий зах зээлд нийлүүлж буй аливаа бүтээгдэхүүн гэж ойлгох бөгөөд үүнд мөн маркетингийн зориулалттай бусад зүйлсийг хамруулж ойлгоно.
Прүүвэ компани гэдгийг Польш улсын Фабричний гудамж дахь мужийн шүүхийн Улсын Бүртгэлийн Эдийн засгийн 6-р хэлтсийн КРС: 0000665414 тоот бүртгэлтэй, НИП 8992810863, РЕГОН: 366657707 компанийг ойлгоно. Хаяг: 53-012 Вроцлав хот, Выгчигова гудамжны 56Н, Вроцлав.
13. **Прүүвэ Монгол дахь салбар** гэдгийг Монгол Улсын Улсын Бүртгэлийн №000157182 тоот гэрчилгээтэй, регистрийн 6272622 дугаартай БГД 6-р хороо “Gem mall” худалдааны төв 4 давхар гэсэн албан ёсны хаяг бүхий Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийг ойлгоно.
14. **Амбассадоруудын Зөвлөл** гэдгийг Прүүвэ Монгол дахь салбарын захирлаар удирдуулсан, Амбассадор цол бүхий зөвлөлийн шаардлагыг хангасан Түншүүдээс бүрдэх зөвлөх үйлчилгээ олгодог нэгж гэж ойлгоно. Уг нэгжийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг тусгай баримт бичгээр зохицуулна.
15. **Прүүвэ Монгол дахь салбарын цахим хуудас /вэбсайт/ гэдгийг** Прүүвэ Монгол дахь салбарын эзэмшдэг цахим хуудас гэж ойлгох бөгөөд уг цахим хуудас нь Прүүвэ Монгол дахь салбар болон хамтын ажиллагааны гэрээ байгуулсны үндсэн дээр <http://www.mn.prouve.com> цахим хуудасд өөрийн хаяг нууц үгээр нэвтрэн бүтээгдэхүүний худалдан авалт, борлуулалт хийх эрх бүхий Түншийн бүтээгдэхүүн борлуулах, худалдаж авах үйлчилгээг үзүүлнэ.
16. **Прүүвэ Монгол дахь салбарын онлайн /цахим/ дэлгүүр** гэдгийг <http://www.mn.prouve.com> хаягаар нэвтрэх Прүүвэ Монгол дахь салбарын цахим үйлчилгээ бүхий онлайн дэлгүүр гэж ойлгох бөгөөд уг онлайн дэлгүүр нь Прүүвэ Монгол дахь салбар болон Түншийн бүтээгдэхүүн борлуулах, худалдаж авах үйлчилгээг үзүүлнэ.
17. **Спонсор** гэдгийг энэхүү гэрээнд Спонсор гэж тодорхойлсон Түншийг гэж ойлгоно.

18. **Баг** гэдгийг тодорхой Түншийн (өөрөөр хэлбэл Спонсорын) удирдлагад ажиллаж буй хэсэг бүлэг Түншүүдийг гэж ойлгох бөгөөд уг багийг Прүүвэ Монгол дахь салбарынТүнш (Спонсор) хамтран ажиллах хүсэлт бүхий хүнд санал болгож улмаар тухайн хүсэлт гаргагч нь өөрөө мөн компанийн Түнш болж дараагийн хүсэлт гаргагчид Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллахыг санал болгох байдлаар бүрдүүлнэ.
19. **Гэрээ** гэдгийг Түнш болох хүсэлт гаргасан этгээдийн хамтран Түншлэн ажиллах хүсэлт болон компанийн хүлээн зөвшөөрсөн эсэх дээр үндэслэн Түнш болон Прүүвэ Монгол дахь салбарынхооронд байгуулсан гэрээ гэж ойлгоно. Гэрээ болон Карьер төлөвлөлт нь Түнш болон Прүүвэ Монгол дахь салбарынхамтын ажиллагааны нөхцлийг тодорхойлно.
20. **Хамтын ажиллагааны гэрээ** гэдгийг Прүүвэ Монгол дахь салбар болон аж ахуйн нэгж, Түншийн хооронд байгуулсан гэрээ гэж ойлгоно. Үүгээр гэрээний талуудын харилцан хүлээсэн эрх, үүргийг зохицуулна.
21. **Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллах хүсэлт гаргах данс нээлгэх өргөдлийн маягт** (Өргөдлийн маягт) гэдгийг Прүүвэ Монгол дахь салбар-д данс нээлгэх хүсэлтээ илэрхийлэх цаасан болон цахим маягт гэж ойлгоно.
22. **Хамтын ажиллагааны болзол нөхцөл зарчмууд** гэдэгт энд дурдсан бүх зүйл заалтыг хамруулж ойлгох бөгөөд эдгээр нь Гэрээний салшгүй хэсэг болохын зэрэгцээ Түнш болон Прүүвэ Монгол дахь салбарын хамтын ажиллагааны бүх болзол, нөхцөл төдийгүй талуудын харилцан хүлээсэн эрх, үүргийг зохицуулна.

3. Хамтран ажиллах гэрээ байгуулах

- 3.1. Хамтран ажиллах гэрээг байгуулахад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 1) Нас
 - 2) ХХК/Аж ахуй нэгж, хуулийн этгээд
 - 3) ХК/ Аж ахуй нэгж, хуулийн этгээд
- 3.2. Гэрээг дараах хэлбэрүүдээс сонгон байглна. Үүнд:
 - 1) Биеээр буюу бичгээр өөрөөр хэлбэл Хүсэлт гаргагч Прүүвэ Монгол дахь салбараас олгох хамтран ажиллах хүсэлтийн маягтыг үнэн зөв бөглөж гарын үсгээ зурж баталгаажуулан нэг хувийг Прүүвэ Монгол дахь салбар-д өгнө. (Хаяг: БГД 6-р хороо “Gem mall” худалдааны төв 4 давхар).
 - 2) Цахим хэлбэрээр өөрөөр хэлбэл www.mn.prouve.com хаягаар орж цахим бүртгэл хийлгэнэ. Хамтын ажиллагааны гэрээ байгуулах хүсэлт гаргагч нь цахим өргөдлийн маягтыг үнэн зөв бөглөж баталгаажуулан Прүүвэ Монгол дахь салбар-д илгээнэ.
 - 3) Хамтын ажиллагааны гэрээ байгуулах хүсэлт бүхий аж ахуйн нэгж нь хүсэлтийн маягтыг үнэн зөв бөглөж баталгаажуулснаар хүсэлт гаргагч болно.
- 3.3. Прүүвэ Монгол дахь салбар нь гэрээ байгуулахад шаардлагатай гэж үзсэн нэмэлт бичиг баримтыг хүсэлт гаргагчаас шаардах эрхтэй.
- 3.4. Дараах тохиолдолд Хамтын Ажиллагааны Гэрээг байгуулж, Түншийн дугаарыг нээнэ. Үүнд:
 - 1) “Прүүвэ Монголиа” ХХК-тай хамтран ажиллах хүсэлт гаргагч нь хүсэлт буюу гэрээ байгуулах саналтай танилцсан даруй уг хүсэлтэд бичигдэх өөрийн хувийн мэдээллийг “Прүүвэ Монголиа” ХХК-д өгөхийг зөвшөөрч өөрийн хувийн мэдээллийг өгсөн нь гэрээ байгуулсанд тооцогдоно гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрсөнөөр;

- 2) (бичгээр Өргөдлийн маягт мэдүүлсэн хүсэлт гаргагчийн тухайд:) Прүүвэ Монгол дахь салбарынэрх бүхий төлөөлөгч хүсэлт гаргагчийн үнэн зөв бөглөсөн өргөдлийн маягтыг баталгаажуулж гарын үсэг зурснаар;
 - 3) (цахимаар Өргөдлийн маягт мэдүүлсэн Хүсэлт гаргагчийн тухайд:) Прүүвэ Монгол дахь салбар-аас хүсэлт гаргагчийн хувийн цахим шуудан руу илгээсэн хамтын ажиллагааг идэвхжүүлэх холбоосыг хүсэлт гаргагч хүлээн авч баталгаажуулснаар.
- 3.5.** Арван зургаан нас хүрсэн 18-аас доош насны (өөрөөр хэлбэл насанд хүрээгүй) этгээд өөрийн хууль ёсны асран хамгаалагчаас олгосон зөвшөөрлийн бичгийг хавсаргаж баталгаажуулсны үндсэн дээр түнш болж болно. Насанд хүрээгүй этгээдтэй гэрээ байгуулах тохиолдолд зөвхөн бичгээр байгуулна. Насанд хүрээгүй этгээд өргөдлийн маягтыг хоёр хувь бичгээр үйлдэн өөрийн хууль ёсны асран хамгаалагчаас олгосон зөвшөөрлийн бичгийг хавсарган Прүүвэ Монгол дахь салбар-д мэдүүлнэ. Прүүвэ Монгол дахь салбарынэрх бүхий төлөөлөгч хүсэлт гаргагчийн үнэн зөв бөглөсөн өргөдлийн маягтыг баталгаажуулж гарын үсэг зурснаар гэрээг байгуулна.
- 3.6.** Гэрээг байгуулснаар түншид түншийн хувийн дугаар олгоно. Хамтын ажиллагааны болзол, нөхцөл, гэрээ болон карьер төлөвлөлтөнд өөрөөр заагаагүй тохиолдолд түнш тус бүр зөвхөн нэг хувийн дугаартай байна.
- 3.7.** Түншийн хувийн дугаарыг бусдад худалдах, шилжүүлэх, зээлүүлэх болон бусад зүйд үл нийцэх үйлдэлд ашиглахыг хоргилно.
- 3.8.** Гэрээ байгуулж данс нээсний дараа түнш нь Прүүвэ Монгол дахь салбарын www.mn.prouve.com цахим хуудасд өөрийн нэвтрэх нэр, өөрөөр хэлбэл хүсэлт гаргагчийн мэдүүлсэн цахим шуудангийн хаяг, нууц үгээ бичиж нэвтрэнэ. Түнш нь өөрийн болон багийн бусад түншийн аливаа мэдээллийн нууцлалыг хамгаалж, гуравдагч этгээдэд задруулахгүй үүрэг хүлээнэ. Түнш нь нууц үгээ алдсанаас үүсэх аливаа үр дагаврыг өөрөө бүрэн хариуцна. Прүүвэ Монгол дахь салбар нь түншийн дансны аливаа мэдээллийн нууцлалыг хадгалах, түншийн дансыг гуравдагч этгээдийн хандлагаас мөн хууль бусаар ашиглахаас сэргийлэх техникийн бүхий л боломжит арга хэмжээг авна.
- 3.9.** Гэрээг байгуулсны дараа түншийг хүсэлтийн маягтад дурдсан спонсорын багт даруй бүртгэнэ. Хүсэлт гаргагч нь ямар нэгэн Спонсорыг дурдаагүй тохиолдолд тухайн хүсэлт гаргагчийг Прүүвэ Монгол дахь салбарын томилсон спонсорын багт бүртгэнэ. Мөн тухайн спонсорын багт бүртгэх боломжгүй эсвэл бүртгэхийг зөвшөөрөөгүй тохиолдолд мөн компанийн зүгээс өөр спонсорын багт томилно.
- 3.10.** Прүүвэ Монгол дахь салбарын түншийн эхнэр/нөхөр нь мөн компанийн түнш болсон тохиолдолд зөвхөн нөхөр/эхнэрийн багт бүртгүүлнэ. Хэрэв эхнэр нөхөр өөр багт бүртгүүлсэн тохиолдолд тухайн тохиолдлыг судлаж компани шийдвэр гаргана.
- 3.11.** Түнш нь Прүүвэ Монгол дахь салбартай гэрээг байгуулсан тохиолдолд мөн компанийн гадаад салбартай хамтран ажиллахын тулд гэрээ байгуулах үүрэг хүлээхгүй, өөрөөр хэлбэл заавал гэрээ байгуулах ёсгүй болно.
- 3.12.** Дараах тохиолдолд гэрээ байгуулахаас татгалзана. Үүнд:
- 1) Хэрэв хүсэлт гаргагч хэдийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан түнш, компанийн бусад салбарын түнш бол;
 - 2) Хүсэлт гаргагч өмнө нь байгуулсан гэрээ, хамтран ажиллах журмыг (Хамтын ажиллагааны болзол, нөхцөл, гэрээ зэрэг) зөрчсөний улмаас мөн Прүүвэ Монгол дахь салбар болон төв компанийн бусад салбартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг зөрчсөн, итгэлцэлийг алдсаны улмаас гэрээ цуцлагдсан тохиолдолд;

- 3) Хүсэлт гаргагч өмнө нь компанийн түнш, компанийн салбарын түнш байсан бөгөөд өмнө хамтын ажиллагааны гэрээг зөрчиж байгаагүй урьд нь байгуулсан хамтран ажиллах гэрээг цуцалснаас хойш зургаан сар өнгөрөөгүй байгаа тохиолдолд;
- 4) Хүсэлт гаргагч хүсэлтийн маягтыг худал, буруу бөглөж мэдүүлсэн мөн шаардсан баримт материалыг өгөөгүй тохиолдолд;
- 5) Хүсэлт гаргагчтай гэрээ байгуулахад саад болох хууль эрх зүйн болон бусад хүчин зүйлс байгаа тохиолдолд.

4. Хамтран ажиллах болзол, нөхцөл санал

4.1. Түншийн эрх, үүрэг

- 4.1.1. Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажилласнаар түнш нь бие даан өөрийн эрсдэлийг хариуцан ажиллана.
- 4.1.2. Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллахдаа Түнш өөрийн биеэр эсвэл албан ёсны, баталгаат бичгээр үйлдсэн итгэмжлэл бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгч, төлөөлөлөөр дамжуулан бүхий л үйл ажиллагааг явуулна. Прүүвэ Монгол дахь салбар-тай өөрийн итгэмжит бус төлөөлөгч, төлөөлөлөөр дамжуулан, өөрөөр хэлбэл өөр хувь хүн болон аж ахуйн нэгжийн нэрийг ажиллахыг хориглоно.
- 4.1.3. Прүүвэ Монгол дахь салбараас урьдчилан бичгээр зөвшөөрөл өгч эрх олгоогүй ямар ч тохиолдолд Түнш нь Прүүвэ Монгол дахь салбарын нэрийн өмнөөс эсвэл компанийг төлөөлж ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбарын нэрийн өмнөөс эсвэл компанийг төлөөлж үйл ажиллагаа явуулах эрхгүй бөгөөд Түнштэй бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, төлөөллийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ болон бусад ижил төстэй гэрээг байгуулахгүй. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбарын нэрийн өмнөөс эсвэл компанийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрхтэй мэтээр гуравдагч этгээдийг төөрөгдүүлэх ёсгүй.
- 4.1.4. Түнш нь гуравдагч этгээдтэй үүсгэх аливаа харилцаа, үйл ажиллагаанд “Прүүвэ Монгол дахь салбарын бие даасан Түнш” нэрийг ашиглана. Мөн гадаад харилцааны аливаа үйл ажиллагаанд Түнш нь Карьер төлөвлөлтөнд заасан багийн амжилтын түвшинд үндэслэгдэн олгогдсон Түншийн байр суурийг илэрхийлэх “Амбассадор” эсвэл “Элит Амбассадор” цолоос өөр нэр, цол ашиглахгүй.
- 4.1.5. Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажилласнаар Түнш нь дараах эрхийг эдлэнэ. Үүнд:
 - 1) Прүүвэ Монгол дахь салбар-аас бүтээгдэхүүн захиалах, худалдан авах; Прүүвэ Монгол дахь салбар-аас худалдан авалт хийснийг баталгаажуулах баримт бичгийг хүлээн авах;
 - 2) Прүүвэ Монгол дахь салбар-аас худалдан авсан бүтээгдэхүүнийг борлуулахын тулд өөрийн хэрэглэгчтэй болох; хэрэглэгчдээс захиалга авах, цуглуулах; Прүүвэ Монгол дахь салбар-аас худалдан авсан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд шууд борлуулах;
 - 3) Бүтээгдэхүүн сурталчлах, урамшуулал олгох зэрэг маркетингийн үйл ажиллагаа явуулах;
 - 4) Хэрэглэгчдэд бүтээгдэхүүн болон үйлчилгээ зэрэг түүнтэй холбоотой бүхий л мэдээллийг танилцуулах.
- 4.1.6. Прүүвэ Монгол дахь салбарын зүгээс Түншүүдээсээ бүтээгдэхүүнийг хадгалах, тодорхой нөөцийг бүрдүүлэхийг шаардахгүй. Компани нь Түншүүдийн борлуулсан бүтээгдэхүүнийг тооцон карьер төлөвлөлтөд заасны

дагуу урамшууллыг дараа сардаа багтаан олгоно. Прүүвэ Монгол дахь салбар-д бүртгэлтэй түншийн нэр, тухайн түншийн урамшууллаа хүлээн авахаар бүртгүүлсэн банкны данс эзэмшигчийн нэр зөрж байгаа тохиолдолд түнш урамшууллыг нэхэмжлэх эрхгүй.

- 4.1.7. 10,000 төгрөг ба түүнээс доош хэмжээтэй урамшууллыг бэлэн болон бэлэн бус гүйлгээгээр нэхэмжлэх эрхгүй ба дараагийн бараа захиалгын үнийн дүнд тооцуулах эсвэл түнш дансандаа хуримтлуулж зөвшөөрөгдөх хэмжээнд хүрсэн тохиолдолд нэхэмжилнэ.
- 4.1.8. Түнш нь бүтээгдэхүүний захиалга хүлээн авах Прүүвэ Монгол дахь салбарынбайнгын зуучлагчийн үүрэг хүлээхгүй.
- 4.1.9. Түнш бүр энэхүү гэрээ, үйл ажиллагааны болон хамтран ажиллах журам бүхий хамтын ажиллагааны болзол, нөхцөл, карьер төлөвлөлт болон ёс суртахууны зарчим бусад холбогдох хууль, тогтоомжид заасан журмын дагуу үйл ажиллагаа явуулах үүрэгтэй. Дээр дурдсанчлан, Түншийг Прүүвэ Монгол дахь салбар-тай байгуулсан гэрээ, үйл ажиллагааны болон хамтран ажиллах журам бүхий хамтын ажиллагааны болзол, нөхцөл, карьер төлөвлөлтөнд шууд болон шууд бус байдлаар харшлах, зөрчилдөх аливаа үйлдэл хийхийг хориглох бөгөөд Түнш ийм үйлдэл, үйл ажиллагаа хийсэн нь тогтоогдсон тохиолдолд хамтран ажиллах гэрээг цуцлана.
- 4.1.10. Түнш нь залилан хууран мэхлэх болон хууль бус бизнесийн аливаа үйл ажиллагаа явуулахгүй байна.
- 4.1.11. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбар-аас зар сурталчилгаа, урамшуулалын зорилгоор бэлтгэж хангаж буй материал, бүтээгдэхүүнийг ашиглан маркетинг, урамшуулал, зар сурталчилгаа болон танилцуулга, мэдээллийн үйл ажиллагаа явуулна.
- 4.1.12. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбарыннэр, Брэнд нэр, Худалдааны тэмдэг, Бүтээгдэхүүний нэр болон танилцуулга, мэдээллийн материал, гэрэл зураг, Прүүвэ Монгол дахь салбарынэзэмшиж буй эрхийг энэхүү Гэрээний 4.1.10-т зааснаас бусад зорилгоор ашиглахыг хүсвэл Прүүвэ Монгол дахь салбар-аас урьдчилан бичгээр үйлдсэн зөвшөөрөл авах шаардлагатай. Уг бичгээр үйлдсэн зөвшөөрөлд тухайн зөвшөөрлийн хамрах хүрээ, хэрэгжих хэлбэр, хугацааг нарийн зааж зохих эрхийг олгосон тухай дурдсан байна.
- 4.1.13. Түнш нь энэхүү гэрээ болон түүний салшгүй хэсэг болох хавсралтуудад заасан өөрийн эрх, үүргийг доор үзүүлснээс бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй. Үүнд:
 - 1) Түнш нас барсан тохиолдолд энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу өв залгамжлагчид шилжүүлэх;
 - 2) Холбогдох хуулийн хүрээнд энэ үйлдэл нь зөвшөөрөгдсөн бол.
- 4.1.14. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбар-д мэдэгдсэний үндсэн дээр Прүүвэ Монгол дахь салбар-тай байгуулсан хамтын ажиллагаагаа цуцалж болно.
- 4.1.15. Энэхүү гэрээний 4.1.13-т заасан хамтын ажиллагааг цуцлах мэдэгдэл хүргүүлсэн тохиолдолд Түнш худалдан авсан бараа бүтээгдэхүүнийг компанид буцаах боломжгүй.

4.2. Прүүвэ Монгол дахь салбарынүүрэг

- 4.2.1. Түнштэй хамтран ажилласнаар Прүүвэ Монгол дахь салбар нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 1) Түншүүдийн сүлжээг зохион байгуулах;
 - 2) Түншид Бүтээгдэхүүн худалдах, нийлүүлэхийн тулд хамтын ажиллагааны гэрээнд заасан бүхий л нөхцөлийн дагуу бүтээгдэхүүний захиалга хийх үүрэг хүлээнэ. Захиалга бүр нь зохих шаардлага хангасан байна;

- 3) Энэхүү гэрээний салашгүй хэсэг болох Карьер төлөвлөлт болон Хамтын ажиллагааны болзол, нөхцөлийн дагуу Түншид урамшуулал олгоно.
- 4.2.2. Түншид бүтээгдэхүүнийг түншийн үнээр тооцон Прүүвэ Монгол дахь салбарынцахим хуудас дахь өөрийн дансаар нэвтэрч холбогдох Прүүвэ Монгол дахь салбарынонлайн дэлгүүрт тодорхойлсон нөхцлийн дагуу худалдана.
- 4.2.3. Тодорхой бүтээгдэхүүн худалдан авсан Түншид оноо өгөх бөгөөд Түнш худалдан авалт хийх бүрт Прүүвэ Монгол дахь салбарын www.mn.prouve.com цахим хуудас дахь онлайн дэлгүүрт Түншийн оноог тогтоож өгнө. Түнш онлайн дэлгүүрт өөрийн дансаар нэвтрэнэ.

4.3. Харилцан хүлээх үүрэг

Энэхүү гэрээний Талууд нь өөрсдийн мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт гарсан тохиолдолд тухайн өөрчлөлт гарсан өдрөөс 7 хоногийн дотор хугацаа алдалгүй нөгөө талд нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

4.4. Хамтын ажиллагаанд эзлэх байр суурь, тус бүрийн эрх, үүрэг

- 4.4.1. Түнш нь дараах байдлаар Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллаж болно. Үүнд:
 - 1) Хэрэглэгч
 - а) Бүтээгдэхүүнийг зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан худалдан авахын зэрэгцээ Прүүвэ Монгол дахь салбар-аас худалдан авсан Бүтээгдэхүүнийг өөрөө, дансаараа шууд борлуулах боломжийг ашиглахгүй;
 - б) Спонсор биш байж болно;
 - в) Элсэлтийн багцыг худалдаж авахгүй байж болно.
 - 2) Түнш
 - а) Бүтээгдэхүүнийг зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан худалдан авахын зэрэгцээ Прүүвэ Монгол дахь салбар-аас худалдан авсан бүтээгдэхүүнийг өөрөө, дансаараа шууд борлуулах боломжийг нээлттэй ашиглаж болно;
 - б) Спонсор байж болно;
 - в) Элсэлтийн багцыг худалдаж авах үүрэгтэй.
 - 3) Аж ахуй эрхлэгчид:
 - а) Бүтээгдэхүүний жижиглэн худалдаа, мөн зорилгоор маркетингийн үйлчилгээ явуулдаг байж болно;
 - б) Спонсор байж болно;
 - в) Элсэлтийн багцыг худалдаж авах үүрэгтэй.
- 4.4.2. Аливаа бизнесийн үйл ажиллагаанд ямар нэг байдлаар оролцогч хэрэглэгч болон Түнш нь тухайн бизнесийнхээ тухай бичгээр мэдэгдэж холбогдох бичиг баримтуудыг хавсарган Прүүвэ Монгол дахь салбар-д мэдэгдэнэ. Мөн уг мэдээлэлд өөрчлөлт гарсан даруйд компанид мэдэгдэх үүрэгтэй.
- 4.4.3. Түнш нь бүтээгдэхүүний захиалгын төлбөрийг тухай бүрд нь төлөх үүрэгтэй. Энэхүү үүргийг зөрчсөн тохиолдолд Прүүвэ Монгол дахь салбар Түншийн дараагийн захиалгыг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

4.5. Түнш бүтээгдэхүүн борлуулах

- 4.5.1. Прүүвэ Монгол дахь салбар нь бүтээгдэхүүн борлуулах гараас гарт буюу шууд борлуулалтын системтэй бөгөөд энэ нь бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд (бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчид) шууд худалдаалах жижиглэн худалдаа гэсэн үг юм. Энэ тохиолдолд бүтээгдэхүүнийг дэлгүүр, мухлаг, лангуу, зах болон бусад жижиглэн болон бөөний худалдааны газрууд гэх мэт гараас гарт худалдаалах зориулалтын бус орчинд бусад хэлбэрээр борлуулахгүй.
- 4.5.2. Прүүвэ Монгол дахь салбарынсанал болгож буй бүтээгдэхүүн нь тус компанид бүртгэлтэй Түншийн ажиллаж, борлуулж буй улс орны холбогдох

хуулийн шаардлагыг хангасан болно. Прүүвэ Монгол дахь салбар нь тус компанид бүртгэлтэй Түншийн ажиллаж, бүтээгдэхүүн борлуулж буй улс орноос бусад орны буюу гуравдагч орны нутаг дэвсгэр дээр бүтээгдэхүүнтэй холбогдон үүссэн аливаа хохирол, нэхэмжлэлд Түнш эсвэл гуравдагч этгээдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.

- 4.5.3. Түнш нь хэрэглэгчид бүтээгдэхүүний тухай болон хангамжийн талаар зохих ёсоор мэдээлэх үүрэгтэй бөгөөд үүнд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:
 - 1) Бүтээгдэхүүний шинж чанар, үйлчилгээг Прүүвэ Монгол дахь салбар-аас тодорхойлж зааснаас өөрөөр тайлбарлах;
 - 2) Хугацаа нь дууссан болон эвдрэл, гэмтэлтэй бүтээгдэхүүн өгөх;
 - 3) Битүүмж халдагдсан болон хадгалалтын горим зөрчигдсэн бүтээгдэхүүн өгөх гэх мэт
- 4.5.4. Прүүвэ Монгол дахь салбар нь бүтээгдэхүүнийг зүй бусаар хэрэглэхэд нөлөөлсөн гэх үндэслэлээр хэрэглэгч Түншийн эсрэг нэхэмжлэл гаргахад хүргэсэн байж болох Түншийн дугуу дулимаг болон бусад үйлдэлд хариуцлага хүлээхгүй.
- 4.5.5. Түнш бүтээгдэхүүнийг худалдахдаа худалдаа үйлчилгээний тухай нийтлэг мөрдөгддөг МУ-ын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

4.6. Цахим хуудас, нийгмийн сүлжээнд хуудас нээх, эрхлэхэд баримтлах журам

- 4.6.1. Прүүвэ Монгол дахь салбар нь Түншид бүтээгдэхүүнийг худалдах, Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллах боломжийг сурталчлах зорилгоор цахим орчинд /интернэтэд/ өөрийн бие даасан цахим хуудас нээн, эрхлэн ажиллуулахыг зөвшөөрнө. Уг цахим хуудас нь бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдах болон үзүүлэн таниулах, мэдээлэх зэрэг Прүүвэ Монгол дахь салбарын зохиогчийн эрхийг дангаар эзэмшдэг бусад мэдээллийг дамжуулан олгох цорын ганц зорилго бүхий Түншийн эрхлэх мэдээллийн хэрэгсэл байна.
- 4.6.2. Түнш өөрийн бие даасан Цахим хуудсын нэрийг “Prouve түнш/партнер/.....” гэж өөрийн нэрийг оруулан компанийн албан ёсны цахим хуудас бус пүншийн бие даасан цахим хуудас гэдгийг илэрхийлэн нэрлэх ба компанийн эзэмшдэг “Prouve” нэрийг өөр байдлаар ашиглахыг хориглоно. Жишээ нь: “Prouve түнш Наран” гэх мэт
- 4.6.3. Түнш нь энэхүү гэрээний 4.1.10-т заасны дагуу Прүүвэ Монгол дахь салбар, бүтээгдэхүүнийг сурталчлах, Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллах боломжийн талаар мэдээлэл нийтлэх цахим хуудсыг дараах байдлаар нээн эрхлэж болно. Үүнд:
 - 1) Прүүвэ Монгол дахь салбарын www.mn.prouve.com цахим хуудас дээр тайлбарласан цахим хуудас нээх, эрхлэхэд баримтлах журамд заасан шаардлагуудыг хангасан байна. Мөн Түншийн нээн эрхлэх гол болон дэд цахим хуудасд дараах мэдээллийг тодорхой, шууд уншигдахуйц байдлаар нийтэлсэн байх нь Түншийн зайлшгүй анхаарах ёстой зүйл болно. Үүнд:
 - а. Түнш цахим хуудасаа Прүүвэ Монгол дахь салбар-д мэдэгдэж бүртгүүлэн албан ёсоор хянуулж зөвшөөрөл авсан байх;
 - б. Уг цахим хуудас нь Түншийн бие даасан хуудас гэдгийг илэрхийлсэн байх бөгөөд Түншийн тухай мөн холбоо барих мэдээллийг тавьсан байх;
 - в. Уг цахим хуудас нь Прүүвэ Монгол дахь салбарыналбан ёсны хуудас биш болохыг илэрхийлсэн байх;
 - г. Прүүвэ Монгол дахь салбарыналбан ёсны цахим хуудас нь www.mn.prouve.com мөн болохыг заасан байна.
 - 2) Прүүвэ Монгол дахь салбар Түншийн бие даасан цахим хуудсыг тус компанийн цахим хуудас нээх, эрхлэхэд баримтлах журамд заасан

шаардлагуудыг хангасан эсэхийг шалгаж баталгаажуулах зөрчил илэрсэн тохиолдолд цахим хуудсыг устгуулах, устгаагүй тохиолдолд хамтран ажиллах гэрээг цуцлах эрхтэй.

- 4.6.4. Түнш өөрийн цахим хуудасдаа Прүүвэ Монгол дахь салбар болон түүний бүтээгдэхүүнүүдтэй холбоотой мэдээ мэдээлэл болон холбогдох цахим хуудаснуудын холбоосыг нийтлэнэ. Түнш цахим хуудасдаа нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомж болон компанийн хамтын ажиллагааны гэрээ, болзол нөхцөлд үл нийцэх мөн ёс суртахуунгүй, худал буюу төөрөгдүүлсэн мэдээ мэдээлэл, бусад холбоосуудыг нийтлэхийг хориглоно.
- 4.6.5. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбарын “Прүүвэ Монголиа, Прүүвэ брэнд, Монголиа брэнд, Прүүвэ бизнес Монголиа, Амжилт Прүүвэ, Прүүвэ сүрчиг” зэрэг нэрийг ашиглаж эсвэл оруулж цахим хуудсын нэрийг үүсгэхгүй.
- 4.6.6. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбарыналбан ёсны цахим хуудас мэт төөрөгдөлд хүргэж болох байдлаар нэр, лого, зураг зэргийг ашиглаж нийгмийн сүлжээнд цахим хуудас нээн эрхлэхийг хориглоно.
- 4.6.7. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбарынзүгээс бичгээр зөвшөөрөл олгоогүй тохиолдолд Прүүвэ Монгол дахь салбар өөрийн цахим хуудасдаа нийтэлсэн мэдээлэл, зураг, дүрс бичлэг /видео/ зэрэг аливаа дүрст болон дүрст бус мэдээллийг ямар нэг байдлаар, өөрөөр хэлбэл өөр хэлбэр загвараар нийтлэх эрхгүй.
- 4.6.8. Прүүвэ Монгол дахь салбарынбэлгэдэл, Прүүвэ барааны тэмдэгийг зөвхөн компанийн www.mn.prouve.com цахим хуудас дээр нийтэлсэн хэв загвар, форматаар ашиглана. Прүүвэ Монгол дахь салбарынбэлгэдэл, Прүүвэ барааны тэмдэгийг засварлаж өөрчлөхийг хориглоно. Түнш нь Прүүвэ Монгол дахь салбарынэээмшдэг бэлгэдэл лого, Прүүвэ барааны тэмдэгийг зөвхөн албан бичгийн хэвлэмэл хуудас болон цахим хуудасны толгой эсвэл хөлд эх хэлбэрээр нь ашиглаж болно.
- 4.6.9. Түнш нь хайлтын системд (жишээ нь, Google Adwords ашиглан) маркетингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тохиолдолд Прүүвэ Монгол дахь салбарынцахим орчинд үйл ажиллагаа явуулахад баримталдаг журмыг мөрдөж, дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:
 - 1) Аливаа зар сурталчилгааг Түнш зохион бүтээж, боловсруулан нийтэлсэн болохыг тодорхой зааж харуулсан байх;
 - 2) “Прүүвэ Монгол дахь салбар”, “Прүүвэ Монгол дахь салбарынбэлгэдэл, Прүүвэ барааны тэмдэг” болон бүтээгдэхүүний нэрсийг түлхүүр үг болгож ашиглах ёсгүй.

5. Үйл ажиллагаа, хориглох үйлдэл

5.1. Ёс зүй

Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтын ажиллагаатай Түнш нь үйл ажиллагаандаа дараах ёс зүйн хэм хэмжээг баримтлана. Үүнд:

- 1) Прүүвэ Монгол дахь салбарынбараа бүтээгдэхүүн болон Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтарч ажиллах гэрээ, болзол, нөхцөлийг үнэн зөв танилцуулах, байнгын болон ирээдүйн хэрэглэгчдэд бүтээгдэхүүний гарал үүсэл, үйлчилгээ, чанар зэрэг мэдээллийг буруу өгч төөрөгдүүлэхгүй байх, компанитай хамтран ажиллахыг сонирхож буй ирээдүйн Түншид компанитай байгуулах хамтын ажиллагааны гэрээ, болзол, нөхцөлийн талаар худал мэдээлэл өгөхгүй байх;

- 2) Бүтээгдэхүүн болон компанитай байгуулах хамтын ажиллагааны гэрээ, болзол, нөхцөлийг танилцуулахдаа зөвхөн Прүүвэ Монгол дахь салбар-аас олгосон танилцуулах материал, хэрэглэгдэхүүнийг ашиглах;
- 3) Бүтээгдэхүүн борлуулах болон Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллахыг санал болгохдоо хууль бус маркетингийн үйл ажиллагаа, зар сурталчилгаа явуулж буруу ташаа мэдээ мэдээлэл өгөн залилахгүй байх;
- 4) Компанийн борлуулалтын хэв шинжид үл нийцэх борлуулалтын арга, сувгаас татгалзаж Бүтээгдэхүүнийг шууд гараас гарт борлуулах;
- 5) Хэрэглэгчдийн захиалгыг цаг тухайд олгож Хэрэглэгчид эрхээ эдлэх боломж олгох;
- 6) Бусад Түнштэй харилцахдаа харилцан хүндэтгэх, шударга байх зарчмыг баримталж, өөр Түншийн багаас гишүүн урвуулахгүй байх, тухайн багт ажиллахаа болихыг ятгахгүй байх;
- 7) Хамтын ажиллагааны гэрээ, журам, болзол, нөхцөл, Карьер төлөвлөлт, Прүүвэ Монгол дахь салбар болон Түншийн хамтын ажиллагаанд хамаарах бусад болзол, нөхцөл мөн нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжуудын заалтуудыг дагаж мөрдөх

5.2. Хориотой үйлдэл, үйл ажиллагаа

5.2.1. Прүүвэ Монгол дахь салбар болон Түншийн тогтоосон хамтын ажиллагааны гэрээ хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанд дараах үйлдэл, үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

- 1) Үйл ажиллагаанд баримтлах хамтын ажиллагааны гэрээ, болзол, нөхцөл, журам зэрэгт харшлах аливаа үйлдэл;
- 2) Зохих мэдлэг, мэдээлэл өгөлгүй, хамтын ажиллагааны гэрээ байгуулалгүй Шинэ Түнштэй хамтарч ажиллах;
- 3) Хийсвэр хувь хүн, аж ахуйн нэгж үүсгэн хамтран ажиллах;
- 4) Урьдчилан мэдэгдэж бичгээр зөвшөөрөл авалгүй өөр Түншээр бүртгүүлэх, өмнөөс нь бүтээгдэхүүн худалдан авах;
- 5) Борлуулалтын бодит хэмжээ буюу эрэлтээс хэтэрсэн хэмжээгээр бүтээгдэхүүнийг худалдан авах, бусад Түншийг мөн үйлдэл хийхийг ятгах;
- 6) Бүтээгдэхүүнийг худалдуулах зорилгоор өөр хувь хүнд (аж ахуйн нэгжид) худалдах, мөн гуравдагч этгээдэд
- 7) Бүтээгдэхүүнийг жижиглэн худалдааны нэгжээр (дэлгүүр, лангуу, мухлаг, зах гэх мэт) худалдах, үзүүлэн таниулах, мөн гараас гарт шууд худалдах гол зарчимд үл нийцэх аливаа хэлбэрээр бүтээгдэхүүнийг худалдах;
- 8) Бүтээгдэхүүнийг каталоги үнээс багаар мөн зөвхөн Түншид санал болгодог 25%-ийн хямдралтай үнээр болон түүнээс хямд үнээр борлуулах;
- 9) Прүүвэ Монгол дахь салбарын баталж зөвшөөрөөгүй мөн тус компанийн зүгээс урьдчилан бичгээр зөвшөөрөл олгоогүй тохиолдолд Прүүвэ Монгол дахь салбарын зохиогчийн эрхийг нь эзэмшдэг Прүүвэ Монгол дахь салбарын бэлгэдэл, Прүүвэ барааны тэмдэг, Бүтээгдэхүүний нэр, аливаа мэдээ мэдээллийн материал, зураг, дүрс зэрэг маркетинг, зар сурталчилгаа, мэдээллийн материалыг ашиглах, тараах, борлуулах;
- 10) Прүүвэ Монгол дахь салбар-тай байгуулсан хамтын ажиллагаанд үндэслэсэн Карьер төлөвлөлтөнд зааснаас өөр амжилтын цол нэр ашиглах;
- 11) Энэхүү гэрээний 4.6 бүлгийн заалтуудыг зөрчсөн байдлаар дээр дурдсан цахим хуудсыг эрхлэх ажиллуулах;
- 12) Багийн болон бусад багийн түшүүдтэй ёс зүйгүй харилцах, бусдыг зүй бус үг хэллэгээр хэлэх, хэн нэгнийг үндэслэлгүй гүтгэх, бүдүүлэг үг хэллэгээр доромжлох, ялгаварлан гадуурхах;

- 13) Үйлчилгээний заал танхимд маргах, бусдад саад болохоор хэт чанга дуугаар ярих, ширээ сандлыг өмчлөх, эмх цэгцгүй бохир суух гэх мэт “Үйлчилгээний танхимд ажиллах журам”-ыг зөрчих;
- 14) Бусад партнерт ижил төстэй үйл ажиллагаа/MLM/ эрхлэгч байгууллагыг санал болгох, бүтээгдэхүүн үйлчилгээг Прүүвэ Монголиа компанийн үндсэн гэрээт салбар, партнер клубын үйлчилгээний заал танхимд авч ирэх, танилцуулан сурталчлах, борлуулах, сургалт уулзалтыг зохион байгуулах;
- 15) Сургалт олон нийтийн арга хэмжээний үеэр урьдчилан хэлэхгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүй хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, Прүүвэ Монголиа компанийн төлөвлөсөн ажилд саад учруулах, нэр хүндийг унагах;
- 16) Санаатайгаар болон санамсаргүй байдлаар бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой худал буруу мэдээлэл өгөх, компанийн болон бизнесийн талаар сөрөг мэдээлэл тараах, нийгмийн сүлжээгээр цацах, бусдыг өдөөн турхрах;
- 17) Нөөц багассан бараа бүтээгдэхүүнийг их хэмжээгээр нөөцөлж авах, багийн гишүүдийн захиалсан бараа бүтээгдэхүүнийг хүргэж өгөхгүй удаах, бусдад ашиглуулах, зөвхөн партнерт санал болгож буй үнээр бараа бүтээгдэхүүн борлуулах;
- 18) Баг хамт олноо мэдээ мэдээллээр хангахгүй, халамжлахгүй байх, үл ойшоох, хүндэтгэлгүй хандах, багийн хамтын ажиллагааг дэмжихгүй байх, хөгжүүлэх, идэвхижүүлэх, алдаршуулах зэрэг үйл ажиллагаа явуулахгүй байх, өөрөөр хэлбэл лидерийн үүргээ гүйцэтгэхгүй байх;
- 19) Прүүвэ Монгол дахь салбарыналбан ёсны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түншийн клуб, салбар, цэг байгуулах, бараа бүтээгдэхүүн борлуулах, 50 ба түүнээс дээш хүнийг хамруулсан сургалт зохион байгуулах;

5.3. Ёс зүйн заалтууд, хоригийг зөрчсөн тохиолдолд үүсэх үр дагавар

- 5.3.1. Энэхүү гэрээний 5.1. болон 5.2. заалтуудыг зөрчсөн тохиолдолд хамтын ажиллагааны гэрээг цуцлах тухай мэдэгдэх хугацааг харгалзалгүй гэрээг нэн даруй цуцлах үндэслэл болно.
- 5.3.2. Түнш хамтран ажиллах гэрээг дагаж мөрдсөн эсэх эсвэл Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллах хугацаанд хориглосон үйлдэл, үйл ажиллагаа хийсэн тухай эргэлзээ, сэжиг төрсөн тохиолдолд Амбасаддоруудын Зөвлөл шалган үүссэн нөхцөл байдлыг үнэн зөвөөр тогтоож, авах арга хэмжээний талаар санал дэвшүүлэн компанид мэдэгдэх ба хариуцлага тооцох эсэх эцсийн шийдвэрийг Прүүвэ Монгол дахь салбар гаргана.

6. Мэдээллийг боловсруулах, хамгаалах

- 6.1. Хувийн мэдээллийн хянагч нь Бүгд Найрамдах Польш Улсын Дээд Шүүхийн Эдийн засгийн 6 дугаар хэсэгт KRS0000665414, БНПУ-ын татвар төлөгчийн дугаар №8992810863, Улсын Бүртгэлийн №366657707 дугаартай Вроцлав хотын Висцигова гудамж 56Н, 53-012 гэсэн албан ёсны хаяг бүхий Прүүвэ Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани (ХХК) болно.
- 6.2. Прүүвэ Монгол дахь салбар нь Европын Холбооны Парламентын баталсан (EU) 2016/679 тоот журам, хувь хүний мэдээллийг боловсруулж эзэмшихэд хувь хүний нууцыг хамгаалах, шилжүүлэх тухай 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн Зөвлөлийн баталсан журам, 95/46/ЕС (Үндсэн Мэдээллийг Хамгаалах тухай Журам) тоот тушаал (цаашид “Журам” гэх) болон 2018 оны 5-р сарын 10-ны өдөр батлагдсан хувийн мэдээллийг хамгаалах тухай Хууль (Хууль, Эрх зүйн эмхэтгэл, 1000 хэсэг, 2018 он) (цаашид “Хууль” гэх) зэрэг нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хүрээнд Түншийн хувийн мэдээллийг боловсруулж эзэмшдэг.

- 6.3.Прүүвэ Монгол дахь салбар нь Түншийн хувийн мэдээллийг дараах зорилгын хүрээнд боловсруулж эзэмшдэг. Үүнд: Хамтын ажиллагааны гэрээ болон хамтын ажиллагааны болзол, нөхцөл мөн Карьер төлөвлөлт зэрэг түүний хавсралтуудыг байгуулах, Түншийн сүлжээг зохион байгуулах, Түнштэй холбоо тогтоох, үнэнч байдлын эсвэл урамшууллын хөтөлбөр зохион байгуулах, Түншээс бүтээгдэхүүний захиалга авах, санхүүгийн төлбөр тооцоо хийх, бизнесийн гүйлгээг баримтжуулах, оноогоор дүгнэх, урамшуулал, цалин хөлс тооцох мөн аливаа үүссэн асуудлыг шийдвэрлэх баримт нотолгоо болгох зэрэгт ашиглана.
- 6.4.Прүүвэ Монгол дахь салбар нь Түнштэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанд Түншийн мэдээллийг боловсруулан эзэмших бөгөөд тухайн хугацаа дуусгавар болоход Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуульд заасан мөн архивын буюу архивын бус бичиг баримтыг хадгалах хугацаанд эзэмшин хадгална.
- 6.5.Энэхүү гэрээ, түүний зүйл заалт болон бүтээгдэхүүн борлуулахтай холбоотой бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Прүүвэ Монгол дахь салбар нь Түншийн хувийн мэдээллийг дараах этгээдүүдэд шилжүүлэх эрхтэй байна. Үүнд: (I) Прүүвэ Монгол дахь салбарынүйл ажиллагааны зорилгын хүрээнд Түншийн хувийн мэдээллийг авч боловсруулж, хадгалах үүрэг бүхий Прүүвэ Монгол дахь салбарынэрх бүхий ажилтан, албан хаагч, хамтрагчид; (II) Прүүвэ Монгол дахь салбарынүйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх мэдээлэл технологийн компани, санхүүгийн алба, хуулийн компани, Прүүвэ Монгол дахь салбарынЗөвшөөрөл авагч /франчайзийг/, Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажилладаг сургалтын байгууллага, Түншүүдэд уулзалт, арга хэмжээ зохион байгуулахад тусалдаг байгууллагууд; (III) Прүүвэ Монгол дахь салбар болон харилцагч банкны үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэдэг шуудан тээвэр, хүргэлтийн компаниуд.
- 6.6.Прүүвэ Монгол дахь салбар нь гэрээ болон хамтын ажиллагааны болзол, нөхцөлийн хүрээнд болон тэдгээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Түншид бусад Түншийн хувийн мэдээллийг олгох, боловсруулах тухай Прүүвэ компанийн холбогдох журмын дагуу Түншид итгэл хүлээлгэх бөгөөд тухайн итгэл хүлээлгэсэн Түнш нь нийтлэг мөрдөгдөх хуулийн дагуу итгэмжилсэн мэдээллийг боловсруулна. Прүүвэ Монгол дахь салбар нь хамтын ажиллагааны гэрээ болзол, нөхцөл болон Карьер төлөвлөлтийн зүйл заалтыг хэрэгжүүлэх мөн Түншийг хувийн цахим хуудасдаа багийн гишүүний хувийн мэдээллийг боловсруулж хэрэглэх зөвшөөрөл, эрх олгохын тулд итгэмжилсэн Түншид бусад Түншүүдийн дараах мэдээллийг боловсруулж эзэмшихийг итгэмжилж байна. Үүнд: (I) Овог нэр; (II) Түншийн хувийн дугаар; (III) цахим шуудангийн хаяг; (IV) Утасны дугаар; (V) Данс нээсэн огноо, Дансны дугаар
- 6.7.Түнш нь (I) Прүүвэ Монгол дахь салбарынитгэмжилсэн хувь хүний мэдээллийг дээр дурдсан 6.6 зүйлд заасан зорилгын хүрээнд боловсруулах ; (II) Прүүвэ Монгол дахь салбар-тай байгуулсан хамтын ажиллагааг дуусгавар болгосон даруй компанийн итгэмжилсэн мэдээллийг компанид буцаах, өөрийн мэдээллийн сангаас тухайн мэдээллийг мөн даруй устгах.
- 6.8.Түнш нь цахим шуудангаар илгээсэн болон хүлээсэн авсан аливаа файлд хувийн мэдээлэл агуулагдсан бол тухайн файлыг нийгмийн сүлжээний цахим хуудсуудад дэлгэгдэхээс сэргийлж хувийн мэдээлэл хамгаалах боломжит хувилбараар хамгаална.
- 6.9.Прүүвэ Монгол дахь салбар нь хувийн мэдээллийг хамгаалахын тулд Түншийн хэрэгжүүлж буй аюулгүй байдлын арга хэмжээг хянах эрхтэй. Түнш нь түүний аюулгүй байдлын арга хэмжээнд хяналт хийх тухай зохих мэдэгдлийг хүлээн авсны дараа даруй Прүүвэ Монгол дахь салбар-д зохих орчин, нөхцөлийг бүрдүүлж өгөх

- 6.10. Түнш нь хувийн мэдээллээ хүлээн авах, хуулбарлах, засаж өөрчлөх, боловсруулах мөн боловсруулах болон бусдад шилжүүлэхийг хориглох эрхтэй.
- 6.11. Түнш энэхүү гэрээтэй танилцаж зөвшөөрөн хувийн мэдээллээ Прүүвэ Монгол дахь салбар-д өгсөн тохиолдолд Түншийн хувийн мэдээллийг ашиглана.
- 6.12. Түнш хувийн мэдээллээ спонсорууддаа харуулахаас татгалзах эрхтэй.
- 6.13. Прүүвэ Монгол дахь салбарын Түнш нь Прүүвэ компанийн зөвшөөрөл авагчид /франчайз/ өөрийн хувийн мэдээллийг өгч болох бөгөөд энэ тохиолдолд Прүүвэ Монгол дахь салбар хувийн мэдээллийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээхгүй. Энэхүү баталгааг ЕХ-ны Комиссын баталсан стандарт гэрээний зүйл заалтуудыг ашиглах үүрэг, Европын Парламентын 2016 оны 7-р сарын 12-ны өдрийн 2016/1250 тоот ЕХ-ны Комиссын Шийдвэрийн дагуу байгуулагдсан ‘Хувийн Нууцлал’ хөтөлбөр мөн ЕХ-АНУ-ын хооронд байгуулсан хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай Зөвлөлийн С(2016) 4176 тоот албан бичгийн дагуу олгоно.
- 6.14. Түнш нь хувийн мэдээллийн аюулгүй байдлын талаар компанид гомдол гаргах эрхтэй.

7. Өв залгамжлал

- 7.1 Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсны үндсэн дээр хамтран ажиллаж байсан Түнш нас барсан болон ажиллах боломжгүй хүндэтгэн үзэх тохиолдол үүссэн үед тухайн хамтын ажиллагааны гэрээгээр (болон бусад холбогдох баримт бичигт) хүлээсэн эрх, үүрэг нь хууль ёсны өв залгамжлагчид шилжинэ.
- 7.2 Нэгээс олон өв залгамжлагч байгаа тохиолдолд дээр заасан эрх, үүрэг нь зөвхөн нэг өв залгамжлагчид шилжих бөгөөд бусад эрх бүхий өв залгамжлагч нар нь тухайн өв залгамжлагчийг нотариатаар баталгаажуулсан албан ёсны тамга тэмдэг бүхийн баримт бичиг эсвэл шүүхийн шийдвэрийн дагуу баталгаажсан байна.
- 7.3 Өв залгамжлагчид дээр дурдсан эрх, үүргийг шилжүүлэхийн тулд өв залгамжлагч нь Прүүвэ Монгол дахь салбар-д өв залгамжлалын эрх үүссэнээс хойш 3 сарын дотор холбогдох баримт бичгүүдийг бүрдүүлж гараар бичсэн өргөдөл хавсарган мэдүүлнэ.
- 7.4 Энэ бүлгийн 7.3-т заасан өв залгамжлагч нь Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажилладаг Түнш бол нас барсан Түншийн эрх, үүргийг хариуцаж эхэлсэн цаг мөчөөс эхлэн тухайн өв залгамжлагч болох Түнш нь нас барсан Түншийн хувийн болон өөрийн хувийн дугаарыг ашиглан Прүүвэ Монгол дахь салбар-тай хамтран ажиллаж болно.

8. Нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэл, мэдээллийн нууцыг хамгаалах

- 8.1 “Нууцын зэрэглэлд хамаарах мэдээ мэдээлэл” гэдгийг багийн үйл ажиллагааны тайланд дурдсан бүх мэдээ мэдээлэл, Түншийн дугаарыг олгож гарын үсэг зурсны дараа Түнш болон компанийн хамтын ажиллагааны явцад үүссэн бүх мэдээ мэдээлэл, Прүүвэ Монгол дахь салбарын эзэмшдэг түүний худалдааны үйл ажиллагаатай холбоотой техник, технологи, бүтэц, зохион байгуулалтын тухай мэдээлэл мэдээлэл, Прүүвэ Монгол дахь салбарын зүгээс нууцлалыг хадгалах шаардлагатай гэж үзэн арга хэмжээ авсан компанийн бизнес үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээ мэдээлэл мөн Прүүвэ Монгол дахь салбарын зүгээс “Зөвхөн дотоод хэрэгцээнд”, “Зөвхөн Прүүвэ Монгол дахь салбарын Түншийн хэрэгцээнд” гэж тэмдэглэсэн нууцлалын зэрэгт хамаарах бүхий л мэдээ мэдээллийг хамруулан ойлгоно.
- 8.2 Түнш нь нууцын зэрэглэлд хамаарах аливаа мэдээ мэдээллийн нууцыг хадгалах бөгөөд бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх болон багийн хамтын ажиллагааг дэмжихээс бусад зорилгоор нууцлалын зэрэглэлд хамаарах мэдээ мэдээллийг ашиглахгүй.

- 8.3 Түнш нь Прүүвэ Монгол дахь салбар-д урьдчилан мэдэгдэж бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд гуравдагч этгээдэд нууцлалын зэрэгт хамаарах компанийн мөн багийн, өөрийн зэрэг мэдээ мэдээллийг дамжуулахгүй, ашиглуулахгүй, задруулахгүй байх үүрэгтэй.
- 8.4 Түнш өөрийн хувийн нууцад хамаарах мэдээллээ бусдад задруулсанаас үүсэн гарсан асуудал хохиролыг Прүүвэ Монгол дахь салбар хариуцахгүй

9. Гэрээний дуусах хугацаа, гэрээг зогсоох, гэрээ болон хамтын ажиллагааг цуцлах

9.1. Гэрээ дуусгавар болох нь

9.1.1. Гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

- 1) 7 дугаар бүлэгт дурдсан буюу Түнш нас барсан ажиллах боломжгүй хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд;
- 2) Түнш буюу Түншийн бизнесийн үйл ажиллагаа дампуурсан тохиолдолд;
- 3) Хуулийн этгээд буюу худалдааны үйл ажиллагаа эрхлэдэг компанийг татан буулгах тохиолдолд;
- 4) Прүүвэ Монгол дахь салбар Түншээс өөрийн хувийн мэдээллийг ашиглах тухай олгосон зөвшөөрлөө цуцлах мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд;
- 5) Прүүвэ Монгол дахь салбар Түншээс Прүүвэ Монгол дахь салбарынбүтэц, зохион байгуулалтаас гарч буйгаа болон 4-р бүлэгт заасан эрх, үүргээс татгалзаж буйгаа илэрхийлсэн мэдэгдэл хүлээн авч судлан зөвшөөрсөн тохиолдолд;
- 6) Түнш эхний нэг жилийн хугацаанд Прүүвэ Монгол дахь салбар-аас бүтээгдэхүүн худалдан авч 100 хүртэл оноо цуглуулаагүй тохиолдолд (Гэрээний хүчин төгөлдөр хэрэгжих хугацааг тухайн түнш Прүүвэ Монгол дахь салбар-д хувийн мэдээллээ өгч хамтын ажиллагааны гэрээг байгуулсан өдрөөс эхлэн дараа жилийн мөн өдрийг хүртэл тооцоно).

9.1.2. Хамтын ажиллагааны гэрээ нь дээрх 9.1.1-ийн (6)-р зүйлд заасан шалтгааны улмаас цуцлагдсан бол компанийн мэдээллийн систем дэх Түншийн хувийн дугаарыг хүчингүй болгож хаана; хэрэв хувийн дугаар бүхий Түнш асан Прүүвэ Монгол дахь салбар-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээгээ цуцласнаас хойш нэг жилийн дотор гэрээгээ дахин байгуулж хувийн дугаараа сэргээн 100 хүртэл онооны бүтээгдэхүүн худалдан авах хүсэлтээ Прүүвэ Монгол дахь салбар-д мэдэгдсэн тохиолдолд Прүүвэ Монгол дахь салбар Хамтын ажиллагааны гэрээг дахин байгуулж Түншид өмнөх хувийн дугаарыг нь сэргээн олгоно. Түншийн гэрээг цуцласнаас хойш нэг жилийн хугацаа хэтэрсэн тохиолдолд Түншийн дугаар Прүүвэ Монгол дахь салбар мэдэлд бүрэн шилжинэ.

9.2 Гэрээг түр хугацаанд түтгэлзүүлэх (түр зогсоох) тухай

9.2.1. Түнш Прүүвэ Монгол дахь салбар-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, үйл ажиллагаанд баримтлах журам, Карьер төлөвлөлт болон Прүүвэ Монгол дахь салбар болон Түншийн үйл ажиллагаанд хамаатай бусад баримт бичиг, журам, хамтын ажиллагааны болзол, нөхцөлийг зөрчсөн нь тогтоогдсон эсвэл Түнш өөрийн үүргийг биелүүлээгүй тохиолдолд Прүүвэ Монгол дахь салбар Түншид урьдчилан мэдэгдэлгүй, дангаар шийдвэрлэн Түнштэй байгуулсан гэрээг түр хугацаагаар түтгэлзүүлэх (өөрөөр хэлбэл, түр зогсоох) эрхтэй байна.

9.2.2. Хамтын ажиллагааны гэрээг үүссэн нөхцөл байдлыг тодруулж шийдвэрлэх хүртэл түр зогсоож болох бөгөөд түр зогсоох хугацаа нь Түнш Прүүвэ Монгол

дахь салбар-аас гэрээг түр хугацаанд түтгэлзүүлэх буюу зогсоох тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс эхлэн зургаа (6) хүртэл сараас хэтрэхгүй байна.

9.2.3. Гэрээг түр хугацаагаар түтгэлзүүлсэн (зогсоосон) хугацаанд Түншийн хувийн дугаар багийн түвшинд эзлэх байр сууриа хэвээр хадгалах боловч тухайн Түншид энэхүү гэрээ болон түүний хавсралт нь үйлчлэхгүй болно.

9.2.4. Гэрээг түр хугацаагаар түтгэлзүүлсэн (зогсоосон) хугацаа дуусахаас өмнө Түнш болон Прүүвэ Монгол дахь салбар цаашид хамтран ажиллах талаар тохиролцоонд хүрсэн тохиолдолд Түнш хувийн дугаараа сэргээж ашиглах талаар хүсэлт гаргах бөгөөд хувийн дугаар нь багийн түвшинд эзлэх байр сууриа хэвээр хадгална. Прүүвэ Монгол дахь салбар хамтын ажиллагааны гэрээг байгуулсан тохиолдолд Түнш өмнөх Түншийн дугаараа дахин зарлаж, өмнөх байрандаа үлдэнэ. Харин дээрх байдлаар тохиролцоо хийгдээгүй тохиолдолд гэрээг түр хугацаагаар түтгэлзүүлсэн (зогсоосон) хугацааны сүүлийн өдөр дуусгавар болсоноор тухайн Гэрээ хүчингүй болж цуцлагдана.

9.3 Гэрээг цуцлах

9.3.1. Цуцлагч тал нөгөө талдаа долоо хоног өмнө энэхүү Гэрээг цуцлах тухай мэдэгдэх бөгөөд тухайн сар дуусахад мөн гэрээ нь цуцлагдана. Гэрээг цуцлах хүсэлтийг мөн гэрээний дараах талууд гаргаж болно. Үүнд:

- 1) Түнш;
- 2) Хүндэтгэх шалтгааны улмаас Прүүвэ Монгол дахь салбар: Хамтын ажиллагааны гэрээ, болзол, нөхцөлийн 4-р бүлэгийн заалтуудыг биелүүлээгүй буюу зөрчсөн тохиолдолд; хэрэв мэдэгдэл хүлээн авагч нь аж ахуй нэгж, хувьцаат компани бол гэрээг цуцлах хүндэтгэх шалтгаан дурдах шаардлагагүй.

9.3.2. Прүүвэ компанийн салбартай өөрийн хувийн дугаарыг ашиглаж хамтын ажиллагаа эхлүүлэх сонирхолтой байгаа Түнш зохих мэдэгдлийг хүргүүлэн Прүүвэ Монгол дахь салбар-тай байгуулсан гэрээг цуцалснаас хойш 14 хоногийн дотор Прүүвэ компанийн салбартай хамтран ажиллах гэрээ байгуулна.

9.3.3. Түнш энэхүү гэрээ, хамтын ажиллагааны болзол, нөхцөл, Карьер төлөвлөлт үйл ажиллагааны журмуудыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд Прүүвэ Монгол дахь салбар Түншид урьдчилан мэдэгдэлгүйгээр дангаар шийдвэрлэн хамтын ажиллагааны гэрээг цуцлана. Үүнд:

- 1) Өргөдлийн маягтад худал, буруу мэдээлэл бичсэн;
- 2) Түнш өөрийн бизнесийн хамрах хүрээ, бизнес үйл ажиллагааны зогсолт, хязгаарлалт, татвар төлөлт зэрэг өөрийн хууль эрх зүйн байдалд гарсан аливаа өөрчлөлтийн талаар Прүүвэ Монгол дахь салбар-д мэдэгдээгүй тохиолдолд;
- 3) Түнш хуурамчаар хиймэл өсөлт гаргаж их хэмжээний бараа бүтээгдэхүүн захиалах хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр буцаалт, нөхөн төлбөрийн зөрчил үүсгэсэн мөн Прүүвэ Монгол дахь салбар-аас зүй ёсны бус ашиг, нэмэлт орлого хүртэх зорилготой үйлдэл, үйл ажиллагаа явуулсан тохиолдолд;
- 4) Гуравдагч этгээдэд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авалгүйгээр түүний нэрийн өмнөөс эсвэл түүний нэр дээр бизнес эрхлэх буюу захиалга авах;
- 5) Прүүвэ Монгол дахь салбарынашиг сонирхол, нэр хүнд, зах зээлд эзлэх байр суурь, дүр төрхийг сэвтүүлэх, унагаах аливаа үйл ажиллагааг (үйл ажиллагааны хэлбэрээс үл хамааран) санаачилсан, оролцсон нь тогтоогдсон тохиолдолд;
- 6) Багийн үйл ажиллагааг зогсоохын тулд аливаа үйл ажиллагаанд оролцсон, мөн өөр баг болон Түншийн сүлжээнд биечлэн эсвэл өөр хувь хүн, компанийн нэрээр ажилласан нь тогтоогдсон тохиолдолд;

- 7) Энэхүү хамтын ажиллагааны гэрээ, болзол, нөхцөлийн 5.1 болон 5.2 дугаар зүйлийн аливаа заалтыг зөрчсөн тохиолдолд;
- 8) Энэхүү хамтын ажиллагааны гэрээ, болзол, нөхцөлд зааснаас бусад зорилгоор хувийн мэдээллээ ашиглах, Прүүвэ Монгол дахь салбарын зөвшөөрөлгүйгээр хувийн мэдээллээ аутсорсингийн зорилгоор гуравдагч этгээдэд шилжүүлэх, Прүүвэ Монгол дахь салбарын шаардлагын дагуу буруу мэдүүлсэн хувийн мэдээллээ засаагүй тохиолдолд.

9.4 Гэрээг цуцласны дараа талуудын хүлээх үүрэг

Энэхүү гэрээ нь цуцлагдсан тохиолдолд цуцлагдсан шалтгаанаас үл хамааран Түншийн Прүүвэ Монгол дахь салбарын өмнө хүлээх аливаа хариуцлага хязгаарлагдаж хүчингүй болохгүй.

9.5 Гэрээг цуцласны дараах Түншийн бүртгэлийн дугаар, мэдээлэл

Энэхүү Гэрээний 7-р зүйлд заасан нөхцөл болон мөн Гэрээний 4.1.13 зүйлийн (2) хэсэгт заасны дагуу Түнш өөрийн эрх, үүргийг өөр Түншид шилжүүлснээс бусад тохиолдолд гэрээг цуцласан бол цуцлагдсан шалтгаанаас үл хамааран Түншийн дугаар нь багт эзлэх байрандаа хадгалагдах бөгөөд Прүүвэ Монгол дахь салбар нь үүссэн нөхцөл байдлыг дангаар захиран шийдвэрлэнэ.

10. Бусад зүйлс

- 10.1. Энэхүү гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан болно.
- 10.2. Хамтын ажиллагааны болзол, нөхцөл нь энэхүү гэрээний хавсралт бөгөөд Прүүвэ Монгол дахь салбар болон Түншийн хоорондох хамтын ажиллагааны нөхцөлийг заана.
- 10.3. Прүүвэ Монгол дахь салбар нь дараах шалтгаануудын улмаас Прүүвэ Монгол дахь салбар болон Түншийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны болзол, нөхцөл, Карьер төлөвлөлт болон бусад холбогдох бичиг баримтуудад нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй байна. Үүнд: (I) холбогдох хууль тогтоомжийн дагуу бичиг баримтуудын зүйл заалтыг өөрчлөх; (II) Түншид олгох урамшууллыг тодорхойлох/тооцох аргыг өөрчлөх; (III) Түншийн сүлжээнд үйлчлэх Прүүвэ Монгол дахь салбарын мэдээллийн /IT/ системийг өөрчлөх арга хэмжээ авах; (IV) Түншийн гэрээнд эргэлзээ, маргаан үүсгэж буй зүйл заалтуудыг өөрчлөх; (V) Прүүвэ Монгол дахь салбар-д бүтэц, зохион байгуулалтын болон хууль эрх зүйн өөрчлөлт хийх, харин Прүүвэ Монгол дахь салбарын бүтэц, зохион байгуулалт болон нэршлийн өөрчлөлт нь тухайн гэрээ болон хамтын ажиллагааны болзол, нөхцөлд нөлөөлөхгүй болно.
- 10.4. Энэхүү гэрээний 10.3(II) болон (IV) зүйлд өөрчлөлт оруулахдаа шаардалагатай тохиолдолд Амбассадоруудын Зөвлөлтэй урьдчилан зөвлөлдөнө.
- 10.5. Прүүвэ Монгол дахь салбар нэмэлт өөрчлөлт хийсэн тухай бүрд компанийн албан ёсны вэб хуудасаар мэдэгдэх бөгөөд Түнш нэмэлт өөрчлөлтийн тухай мэдээлэл хүлээн авсан өдрөөс эхлэн 3 хоногийн дотор Прүүвэ Монгол дахь салбарын оруулсан нэмэлт өөрчлөлтийг татгалзсан тохиолдолд холбогдох хуульд заасан маягт, загвар, хэлбэрээр компанид мэдэгдэх эрхтэй. Ийнхүү татгалзаж мэдэгдэл хүргүүлэх нь Түншийн компанитай байгуулсан гэрээг тодорхой хугацаанд зогсоох үндэслэл болно. Гэрээг цуцлах тухай мэдэгдлийн хугацаа гэж ойлгоно. Түнш нэмэлт өөрчлөлт оруулсан тухай компаний зүгээс мэдэгдэл аваад 3 хоногийн дотор татгалзсан тухай ямар нэг мэдэгдэл хийгээгүй тохиолдолд Түншийг компанийн оруулсан тухайн нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 10.6. Энэхүү гэрээний бүлгийн гарчигууд нь агуулгыг сэдэвчлэх үүрэгтэй бөгөөд мөн гэрээ, хамтын ажиллагааны болзол, нөхцөл болон Карьер төлөвлөлтийг тайлбарлах зориулалтгүй болно.

10.7. Энэхүү гэрээ, хамтын ажиллагааны болзол, нөхцөл, Карьер төлөвлөлтөнд тусгагдаагүй асуудалд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.